



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/08

Хараат

«Шинэ коронавирусын халдвараас урьдчилан»
сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.15 /в/, 29.1.6 /б/, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/44 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор сумын шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

3. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүд 15 цаг хүртэл архи, согтууруулах ундаа худалдаалах, суманд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн санг хуваарийн дагуу 24⁰⁰ цаг хүртэл ажиллуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шуурхай штаб (Э.Аръяабазар), цагдаагийн хэсэг (Б.Азжаргал) нарт үүрэг болгосугай.

4. Цагаан сарыг өргөнөөр тэмдэглэхгүй, хот, аймаг, сум дамжин золголт хийхгүй байхыг олон нийтэд өргөн хүрээнд сурталчлах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, мэдээ мэдээлэл дотоод ажил хариуцсан ажилтан (Г.Энхжаргал)–д үүрэг болгосугай.

5. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт (хэсэгчлэн) шилжсэнтэй холбогдуулан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт иргэдийг амны хаалт (маск) зүүж хэвшихийг үүрэг болгосугай.

6. Амны хаалт (маск)-ны хангамж хүрэлцээ хангалтгүй байгаатай холбогдуулан нийт иргэдийг амны хаалт (маск)-ыг ахуйн нөхцөлд оёж гэр бүлийн хэрэгцээг хангах, төр хувийн хэвшлийн байгууллагын удирдлагууд өөрийн байгууллагын ажилтан албан хаагчид болон тэдний гэр бүлийг амны хаалт (маск)-жуулах ажлыг зохион байгуулахыг зөвлөсүгэй.

482001020

7.Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн бүх байгууллагууд амны хаалт (маск)-гүй иргэнд үйлчилгээ үзүүлэхийг хориглосугай.

8.Эмнэлэгт үзүүлэхээр ирж байгаа иргэдэд эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийн асуумж бөглүүлэх, амны хаалт байнга зүүлгэх, тусгаарлах өрөө бэлтгэж, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах байгууллагын төлөвлөгөө гарган ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

9.Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллах, Эрүүл мэндийн төвд шаардлагатай байгаа эм, эмнэлэгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын судалгааг тухай бүрт нь гаргаж холбогдох байгууллагуудад болон сумын Онцгой комисст мэдээлж байхыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

10.Албан байгууллага, айл өрх болон гудамж талбай орчны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллахыг Хараат багийн Засаг дарга (Г.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.


11.Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбоотой шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэхийг Санхүүгийн албаны дарга (Ё.Мядагмаа)-д даалгасугай.

12.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

13.Авч хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээ тайланг тухай бүр сумын Онцгой комисс болон аймгийн шуурхай штабт хүргүүлж байхыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Солонго)-д даалгасугай.

14. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга /Э.Аръяабазар/, захирамжийг зөрчсөн төр, хувийн хэвшлийн бүх байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуулийн 5.13.1.2 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ тооцож ажиллахыг холбогдох албан хаагчдад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БУДЖАВ

Сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар
сарын 17-ны өдрийн 1/02 дугаар
захирамжийн хавсралт



ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Э.Аръяабазар-Засаг даргын орлогч

Орлогч: З.Солонго –Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Г.Жаргалмаа -1 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд: И.Эрдэнэбат -2 дугаар багийн Засаг дарга

Г.Дэмбэрэлжав- 3 дугаар багийн Засаг дарга

Д.Мягмардорж –4 дүгээр багийн Засаг дарга

Т.Өлзийбат – Мал эмнэлгийн тасагийн дарга

Ц.Ундрахбаяр –Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

Ё.Мядагмаа –Санхүү албаны дарга

Д.Бат-Орших –Улсын бүртгэгч

Б.Азжаргал –Хэсгийн төлөөлөгч

М.Ёндон- Цагдаа

Б.Алдармаа –Соёлын төвийн дарга

Д.Сарантуяа –Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

А.Мөнхбаатар –Ерөнхий боловсролын сургуулийн захирал

О.Ариунаа –Сургалтын менежер

Д.Ууганбаяр –Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч